



БАЯНХОНГОР АИМГИЙН
БАЯНБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ
ЭМЧ, АЖИЛЧДЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 06

Баянбулаг

Эмч ажилчдын хурал 15 цагт Эрүүл мэндийн төвийн даргын өрөөнд 100%-ийн ирцтэйгээр эхэллээ.

Хурлыг Эрүүл мэндийн төвийн дарга О. Гандиймаа удирдав.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

2024-2026 оны хамтын гэрээг хэлэлцэх, батлуулах тухай

Хэлсэн нь:

О.Гандиймаа (Эрүүл мэндийн төвийн дарга)

Эрүүл мэндийн төвийн ажил олгогчийн төлөөлөгчид, ажилтны пөвлөгчдийн хооронд байгуулах 2024-2026 оны хамтын гэрээг байгууллагын елдвэрчний эвлэлийн хороотой хамтран боловсруулж та бүхнээс санал зөвлөмж ахаар танилцуулж байна.

Үйлдвэрчний эвлэлийн дарга Б. Даваа хамтын гэрээг бүрэн эхээр нь хамт понд уншиж танилцуулав.

А.Дорждэрэм/эмчлэгчэмч/

Миний хувьд уг гэрээг нилээн сайн судалж боловсруулсан байна гэж үзэж анал зөрөх юм байхгүй. Шийдвэр гаргах түвшний хүмүүс бүрэн эрхээр байна гэж ойлгож байна.

Д.Жавхлан /нягтлан бодогч/

Миний хувьд үйлдвэрчний эвлэлийн багийн гишүүн эмч ажилчдаа төлөөлж айгаа хүний хувьд энэхүү гэрээн дээр нилээн чамбай ажиллаж та нарынхаа эрх шгийг алдагдуулахгүй байхын төлөө санал бодлоо илэрхийлж тусгасан тиймээс дэмжиж байна. Үнэхээр сайн болсон байна. Илүү ойлгомжтой, тодорхой болжээ. Өөр саналтай эмч ажилчид байвал санаалаа чөлөөтэй хэлэх хэрэгтэй.

Л.Баярмаа /статистик бага эмч/

Уг гэрээнд тусгагдсан зүйлсийг дэмжиж байна. Илүү ойлгомжтой болсон байна. Иймд холбогдох хууль, дүрэм, материалуудыг сайн судалсан байгаа.

С.Одбаяр /НЭМА

Хамтын гэрээнд ажилтны цалин хөлсийг олгох тухай заасан байсан. Ер нь санхүү мөнгөтэй холбоотой, хуулиар зохицуулагдаагүй заалтуудаа хамтын гэрээнд оруулж өгсөн нь илүү ойлгомжтой болсон байна.

• 642402030

Д.Урнаа /багийн эмч/

Саналыг дэмжиж байна.

Д. Болор-Эрдэнэ /Ахлах сувилагч/

Хамтын гэрээ нь хуулиар зохицуулагдаагүй бидэнд хэрэгтэй зүйл, заалтуудыг оруулж өгдөг. Одоо тэгэхээр үйлдвэрчний эвлэл сайн ажиллаж хамтын гэрээгээ бас хэлэлцэж байгууллагынхаа ажилчдын санхүү, мөнгөтэй холбоотой асуудлыг оруулж өгч байгаа нь зөв юм.

Б.Даваа/багийн эмч/

Надтай хамт үйлдвэрчний эвлэлд байдаг хүмүүс хамтын гэрээгээ нягталж сайжруулан боловсруулсан байгаа. Эмч ажилчид та бүхэн өөрийн бодлоо чөлөөтэй илэрхийлж нэмэх саналаа өгөөрэй:

О.Гандиймаа /ЭМТ-ийн дарга/


Хамтын гэрээний талаар өөр нэмж, хасах санал оруулах хүн байна уу?

Өөр саналтай хүн байхгүй бол хамтын гэрээгээ батлуулахаар Баянхонгор аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газар руу илгээе. Хамт олны 100 хувийн саналаар хамтын гэрээг батлуулах шийдвэр гаргалаа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хамтын гэрээг хамт олны 100%-ийн саналаар дэмжлээ.

ХЯНАСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  О.ГАНДИЙМАА
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН  Д. БОЛОР-ЭРДЭНЭ



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БҮРТГЭВ
БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР
ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

2024. 07. 12

БАЯНБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН АЖИЛ
ОЛГОГЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД, АЖИЛТНЫ ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХООРОНД БАЙГУУЛСАН 2024-2026 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭ

2024. 07. 12

Бүрд

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээг Монгол улсын Нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенц, Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудыг үндэслэн нэг талаас Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн захиргаа захиргаа./ цаашид ажил олгогч гэх / нөгөө талаас нийт ажилчдыг төлөөлж Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн ажилтнуудын ҮЭ-ийн хороо. / цаашид ажилтны төлөөлөгч, хамтад нь талууд гэх/ харилцан тохиролцож байгуулав.
- 1.2. Хамтын гэрээ нь гурван жилийн хугацаанд үйлчилнэ.
- 1.3. Хамтын гэрээ нь талууд гарын үсэг зурж, нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.
- 1.4. Энэхүү гэрээний 1.3-т заасан гэрээний хугацаа дуусахад шинээр гэрээ байгуулаагүй, нэмэлт өөрчлөлт оруулаагүй бол нэг удаа анх байгуулсан хугацаанаас илүүгүй хугацаагаар сунгагдсанаар тооцно.
- 1.5. Энэхүү гэрээний цалин хөлстэй холбоотой зохицуулалтыг нэг жилээс доошгүй хугацаа өнгөрсний дараа дахин хэлэлцээ эхлүүлэхээр санаачлах эрхтэй.
- 1.6. Байгууллагын харьялал, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөн нөхцөлд хамтын гэрээ мөн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 1.7. Талууд хамтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа нөгөө талд энэхүү гэрээний хугацаа дуусгавар болохоос 10 сараас доошгүй хугацааны өмнө гарган бичгээр хүргүүлж байна.
- 1.8. Талууд гэрээнд заасан аливаа асуудалд тэгш эрхтэй оролцох бөгөөд энэхүү хамтын гэрээ хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль тогтоомжид бүрэн нийцсэн байх, хууль тогтоомжоор ажилтанд олгосон эрхийн баталгаат түвшин, суурь хэм хэмжээг бууруулаагүй байх, харилцан тохиролцох замаар ажилтны хувьд сайжруулсан байх зарчмыг баримтална.
- 1.9. Энэхүү хамтын гэрээнд талууд хяналт тавих бөгөөд МҮЭ-ийн гишүүдийг хамаарч үйлчилнэ.
- 1.10. Хамтын гэрээний бүрэн эхийг 3 хувь үйлдэж хамтын гэрээнд оролцогч талууд хадгална.

ХОЁР. ЦАЛИН, ХӨЛС

- 2.1. Байгууллагад мөрдөгдөх ажилчдын үндсэн цалингийн сүлжээг ажил албан тушаал бүрээр гаргаж үндсэн цалингийн сүлжээг Хөдөлмөр нийгмийн түншлэлийн 2 болон 3 талт хэлэлцээрийн дагуу нэмэгдүүлнэ.
- 2.2. Ажил олгогч нь ажилтнуудын цалин хөлсийг бодит инфляцын тувшин, ажлын ачаалалтай уялдуулан, Засгийн газраас төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх тохиолдол тус бүрд нэмэгдүүлсэн хувиар нэмэгдүүлнэ.
- 2.3. Ажил олгогч нь хөдөлмөрийн дотоод журам албан тушаалын жагсаалт, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн норм, норматив үндсэн цалингийн сүлжээ, жишиг болон нэмэгдэл хөлс, нэмэгдлийн хэмжээ, шагнал урамшуулал, түүнийг олгох журмыг ҮЭ-ийн хороотой зөвшилцэж баталж мөрдүүлнэ.
- 2.4. Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ ажил албан тушаал хавсран ажилласан бол 40-с доошгүй хувиар, мэргэжил хослон ажилласан бол 40-с доошгүй хувиар, тухайн ажилтны үндсэн тарифт цалингаас нь тус тус тооцон нэмэгдэл хөлс олгоно.
- 2.5. Ажил олгогчийн шаардлагаар илүү цагаар ажилласан бол ажилласан долоо хоногийн аль нэг тохиромжтой ажлын цагт нөхөж амраах, нөхөж амраагүй тохиолдолд илүү цагийн хөлсийг хоёр дахин нэмэгдүүлэн тухайн сарын цалин дээр нь олгох.
- 2.6. Шөнийн илүү цагаар ажилласан бол ажилтанд шөнө ажилласан цаг тутам 2 дахин хувиар нэмэгдүүлэн тооцож нэмэгдэл олгоно.
- 2.7. Ажилтныг 7 хоног бүрийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажиллуулаад нөхөн амруулаагүй бол үндсэн тарифт цалинг 2 дахин нэмэгдүүлж олгоно.
- 2.8. Ажилтанд дараах нэмэгдлүүдийг олгоно. /тодорхой хувь хэмжээ, тоо заавал нэг бүрчлэн заах/
 - a. Тасралтгүй ажилласан жилийн нэмэгдэл
 - b. Мэргэжлийн зэргийн нэмэгдэл
 - c. Ур чадварын нэмэгдэл
 - d. Хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл
 - e. Бусад нэмэгдэл
- 2.9. Хөдөлмөрийн хөлс олгохтой холбогдсон дүрэм журам, тэдгээрт оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр нийт ажилтанд ажил олгогч мэдээлэх үүрэгтэй.
- 2.10. Цалин хөлсийг сард 2 удаа хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд заасан хугацаанд олгох бөгөөд бүх нийтээр амрах болон баярын өдөр таарсан бол ажлын өмнөх өдөр нь олгох бөгөөд цалин хөлсийг хугацаанд нь олгоогүй тохиолдолд хоног тутамд 0,5 хувийн алданги тооцож нэмэгдүүлэн олгоно.
- 2.11. Ажил олгогчоос үл шалтгаалан гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан аюулт үзэгдэл, эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрийн улмаас, эсхүл ажилтнаас үл шалтгаалах сул зогсолтын хугацаанд түүнийг өөр ажилд ~~шилжүүлэх~~

- боловжгүй бол түүнд үндсэн цалингийнх нь 70-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний олговор олгох бөгөөд олговрын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур байж болохгүй.
- 2.12. Эцэгт шинээр төрсөн хүүхдээ асрахад нь зориулан ажлын 10 өдрийн чөлөөг ажил олгогч олгож, тухайн хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговор олгоно.
- 2.13. Хөдөлмөрийн нормоо биелүүлээгүй нь ажилтны буруугаас шалтгаалаагүй бол гүйцэтгэсэн ажилд нь ногдох цалин хөлснөөс гадна үндсэн цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний олговор олгоно.
- 2.14. Ажил олгогч ажилтны хүсэлтээр 2 сарын цалингийн урьдчилгаа олгож болно.
- 2.15. Төрийн одон медалиар шагнуулсан ажилтанд байгууллагын захиргаанаас /Гавьяат эмч/ 300 мянган төгрөг, /Алтан гадас/ 200 мянган төгрөг, /Хөдөлмөрийн хүндэт медаль/ 100 мянган төгрөг, /Эрүүл мэндийн тэргүүний ажилтан/ 50 мянган төгрөг, /Эрүүл мэндийн яамны жуух/ 50 мянган төгрөгийг байгууллагаас гаргаж, ҮЭ-ийн хорооноос гарын бэлэг гардуулна.
- 2.16. Ажилтныг шагнаж урамшуулах асуудлыг удирдлагын багийн хурлаар хэлэлцэн шийдвэрийг хамт олонд тухай бүр мэдээлнэ.
- 2.17. Ажилтан албан хаагчдад ноогдуулсан сахилгын шийтгэл тооцогдох хугацаанд шагнал урамшуулалт ажлын үр дүнгийн нэмэгдлийг олгохгүй.
- 2.18. Жилийн ажлын үр дүнгээр хамт олноо манлайлан ажилласан ажиллагсдыг журмын дагуу жил бүр шалгаруулан оны байгууллагын аварга өргөмжлөл, үндсэн цалингийн 25 хувиар, 250 мянган төгрөгийн эд бараа материалыар урамшуулна.

ГУРАВ. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТ

- 3.1. Захиргаа нь ажлын байранд бүтэц зохион байгуулалт хийдээ өрх толгойлсон, байнгын асаргаа шаардлагатай хүүхэдтэй, тэтгэвэр гаражад нэг жил дутуу байгаа ажилтнуудыг харгалзан үзэж бүтэц зохион байгуулалтад хамруулахгүй байх бодлого баримтална.
- 3.2. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтанд хүүхдийн эмчилгээний зардалд зориулж гаргасан хүсэлт болон эмнэлгийн магадалгааг үндэслэн байгууллагын захиргаанаас жилд 1 удаа 200 мянган төгрөгийн тэтгэмж үзүүлнэ.
- 3.3. Ажилтан шинээр гэр бүл болсон тохиолдолд холбогдох баримт бичгийг үндэслэн 500 мянган төгрөгийн дэмжлэг нэг удаа олгоно.
- 3.4. Байгууллагын захиргаанаас ажилтанд хүүхэд төрүүлж, хүүхэд асрахад нь зориулж өөрийнх нь хүсэлтийг үндэслэн нэг удаа 100 мянган төгрөгийн тэтгэмж олгоно. Энэ тэтгэмж нь нярай хүүхэдтэй ганц бие эцэг, хүүхэд үрчлэн авсан ажилтанд нэгэн адил хамаарна.
- 3.5. Хүндээр өвдсөн, Улаанбаатар болон бусад хотуудад эмчилгээ хийлгэхээр болсон ажилтанд ҮЭ-ийн хорооны тэргүүлэгчдийн шийдвэрээр нэг удаа буцалтгүй тусlamж үзүүлнэ.
- 3.6. Ажилтан нас барсан тохиолдолд, ажил олгогч автомшинаар үйлчилж, ар гэрт нь 500 мянган төгрөгийн мөнгөн тусlamж олгоно.

- 3.7. Ажилтны гэр бүлийн гишүүн/ нөхөр, эхнэр, төрсөн эцэг, эх, хадам эцэг, эх, үр хүүхэд/ нас барвал ажил олгогч автомашинаар үйлчилж, 400 мянган төгрөгийн мөнгөн тусlamж олгоно.
- 3.8. Өндөр насын тэтгэвэрт гарч буй ажилтанд тэтгэмж, 500 төгрөгийн бэлэг дурсгалын зүйлийг ажил олгогч нэг удаа олгоно.
- 3.9. Ажилтан асрамжид байгаа хүмүүсээ /эхнэр, нөхөр, төрсөн эцэг, эх, хүүхдүүд/ хүнд өвчтэй үед нь сахисан тохиолдолд эмчийн магадалгааг үндэслэн 1 сар хүртэл цалинтай чөлөө олгож болно.
- 3.10. Давагдашгүй байгалийн хүчин зүйл болон гэнэтийн аюулд өртөж орон байргүй болсон, хохирол учирсан ажилтанд өргөдөл хүсэлт нөхцөл байдлыг харгалзан 1 сая хүртэлх төгрөгийн буцалтгүй тусlamжийг удирдлагын багийн хурлын шийдвэрийг үндэслэн 1 удаа олгоно.
- 3.11. Ажил олгогчоос ажилтнуудад хоолны мөнгийг өдөрт 2000 төгрөгөөр тооцож олгоно.
- 3.12. Ажиллагсдын чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, хамт олны дунд хамтаж эвсэг уур амьсгалыг төлөвшүүлэх зорилгоор байгууллага хамт олноороо туршлага солилцох, уулзалт зөвлөгөөн гадаад дотоод аялалд оролцох тохиолдолд зардлын 60-70 хүртэлх хувийг байгууллага жилд 1 удаа хариуцна.
- 3.13. Бусад онцгой тохиолдолд олгох тусlamж, тэтгэмж, хөнгөлөлтийг удирдлагын багийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 3.14. Мэргэжилтэн өндөр настны тэтгэвэр тогтоолгосны улмаас хөдөлмөрийн гэрээг цуцалсан бол 12 сар үргэлжлүүлэн хөрвөх мэргэжлээр гэрээ байгуулан ажиллаж болно. Цалингийн шатлалыг үндсэн шатлал, нэмэгдлийг олгож ажиллуулна.
- 3.15. Эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг баримтлан ёс зүйтэй ажилласан ажилтан, эрүүл мэндийн төвийн багуудын ажлын дүгнэж эхний байранд тэргүүлсэн байгийг тус бүр цалингийн 10 хувийн урамшуулалт өгнө.

ДӨРӨВ. АЖИЛ АМРАЛТЫН ЦАГ

- 1.1. Ажил олгогч нь ҮЭ-ийн хорооны саналыг харгалзан ажлын цагийн уян хатан цагийг тогтоон мөрдүүлж болно.
- 1.2. Илүү цагаар болон 7 хоногийн амралт, баяр ёслолын өдрүүдэд ажиллагсдыг ажиллуулахдаа ҮЭ-ийн хороонд мэдэгдэж байна.
- 1.3. Ажил олгогч нь ажиллагсдад доор дурдсан шалтгаан хугацаагаар цалинтай чөлөө олгоно.
 - a. Ажилтан хурим хийвэл ажлын 5 өдөр
 - b. Хүүхэд нь хурим хийвэл ажлын 5 өдөр
 - c. Эцэг эх, хадам эцэг эх, төрсөн ах дүү болон гэр бүлийн хүмүүс нас барвал ажлын 5 өдөр
 - d. Эцэг эх гэр бүлийн хүмүүс өвчилсний улмаас тэднийг асрамжилсан бол ажлын 5 өдөр
 - e. Ажилтан эмнэлэгт хэвтсэн тохиолдолд 7 хоногийн цалинтай чөлөө

f. Ажилтанд жилд нэг удаа 5 хоногийн цалинтай чөлөө

1.4. Ажилтны ажлын цагийг доор дурдсан хэмжээгээр богиносгоно.

а. Мэргэжил эзэмшүүлэх дээшлүүлэх сургалтад хамрагдсан ажилтны ажлын цагийг суралцаж байх хугацаанд нь 1 цагаар

б. 0-1 хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэй ажилчдын /мөн ганц бие эцэг/ ажлын цагийг 1 жилийн хугацаанд өдөр бүр 1 цагаар

с. Бусад

ТАВ. АЖИЛЧДЫН МЭДЛЭГ, МЭРГЭЖЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

- 5.1. Ажилтнуудын ажлын шаардлагаар мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор ажилтан их, дээд сургууль, коллеж болон мэргэжил дээшлүүлэх курст 3 сараас дээш суралцах тохиолдолд ажилтныг суралцах хугацаанд ажлаас чөлөөлж, үндсэн цалин хөлсийг олгож, ажлын байрыг нь хэвээр хадгална.
- 5.2. Эрүүл мэндийн яам болон бусад холбогдох газраас зохион байгуулж буй сургалт семинар албан хаагчдыг цаг хугацаанд нь оролцуулж цалин болон нэмэгдлийг хэвээр олгоно.
- 5.3. Мэргэжил дээшлүүлэх сургалтад жилд 1-ээс доошгүй мэргэжилтнийг хамруулж дотоод журамд заасны дагуу сургалтын төлбөр, замын зардал, цалинг гэрээнд тусгаж олгоно.
- 5.4. Ажил олгогч нь ажилтан албан хаагчийг дэвшин суралцах, давхар мэргэжил эзэмших, хэлний болон компьютерын мэдлэгтэй болох гадаад дотоодод туршлага судлах хүсэлтийн дагуу дэмжлэг үзүүлж ажиллана.

6. ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ

- 6.1. ХАБ-ын ажилтан багаж тоног төхөөрөмж ажлын хувцас худалдан авах ашиглах дүрмийг боловсруулж хэрэгжилтэд дотоод хяналт улирал бүр хяналт тавина.
- 6.2. ХАБ-ын болон дотоод хяналтын ажилтанг хамт олны саналаар сонгон ажиллуулж нэмэгдэл хөлсийг цалингийн 10% олгоно.
- 6.3. Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай үзлэгт хамрагдах ажилтны зардлыг 50-100 хувиар олгоно.
- 6.4. Нийт ажилтан ажиллагсадад хөдөлмөр хамгааллын болон ажил үүргийн онцлогт тохирсон аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн чанарын шаардлагад нийцсэн дараах тусгай хувцсаар бүрэн хангаж хувцасны зардлыг байгууллагаас 100 хувь хариуцна. Үүнд жолооч, галч наарт ажлын хувцсыг иж бүрнээр нь 2 жилд 1 удаа бусад ажилчдад байгууллагын мэргэжилтний ажлын хувцас жилд 1 удаа
- 6.5. Байгууллагын өвөлжилтийн бэлтгэл хангах зардлыг ажил олгогч 100 хувь шийднэ.
- 6.6. Ажил олгогч ажлын өрөө тасалгаа орчин нөхцөлийг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн тохижуулах, ажлын байранд

ГАЯНХОНГОР АЙМГИЙН
Хамтын зэрэгжлийн тогтолцоогоор
Хөдөлмөр хамгаалалтад
УИЛЧИЛГЭЭНД
ХАДГААЛАНД

эрүүл мэндийг дэмжихэд зарцуулах төсвийг жил бүр байгууллагын төсөв хамтын гэрээнд тусгаж зориулалтаар нь зарцуулах арга хэмжээ авна.

- 6.7. Ажлын нөхцөл хөдөлмөр хамгааллын болон эрүүл ахуйн шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд ажилтан нь байгууллагын захиргаанд албан ёсоор танилцуулж зохих арга хэмжээг авхуулна.
- 6.8. Ажилтан нь ажлын байранд ажил үүргээ гүйцэтгэж байхдаа байгууллагын даргын шийдвэрээр тэмцээн, уралдаан, дадлага, сургуулилт хийж байх үедээ бэртэх, гэмтэх зэрэг эрүүл мэндэд хохирол үүссэн тохиолдолд оношилгоо, шинжилгээний зардлыг холбогдох санхүүгийн баримтын үндэслэн байгууллага хариуцна.

7. ХАМТЫН ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 7.1. Энэхүү хамтын гэрээ нь бүртгүүлсэн өдрөөс эхлэн 2024-2026 он дуустал мөрдөгдөнө.
- 7.2. Хамтын гэрээний биелэлтийг ажил олгогч, ҮЭ-ийн хороо улирал тутам гаргаж нийт ажилласдад мэдээлнэ.
- 7.3. Хоёр тал өөрт байгаа гэрээний хэрэгжилттэй холбоотой бүх мэдээллийг тогтмол солилцох үүрэг хүлээнэ.

8. ҮЭ-ИЙН ЭРХИЙГ ХАНГАХ ТУХАЙ


- 8.1. Байгууллагын захиргаа ҮЭ-ийн хорооны үйл ажиллагаа явуулах боломжоор ханган өрөө тасалгаа гаргаж өгөх, техник хэрэгслээр бүрэн хангах үүрэгтэй.
- 8.2. ҮЭ-ийн сонгуультнуудыг нийгмийн асуудлыг шийдвэрлэх, урамшуулалт цалин хөлс олгох, аливаа арга хэмжээнд нийт ажилтнуудын нэгэн адил хамруулна.
- 8.3. Байгууллагын захиргаа нь гишүүдийн татварыг МҮЭ-ийн Холбооны дүрмийн 14.1. “Үйлдвэрчний эвлэлийн хороод нь гишүүдийнхээ татварыг сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нэг ба түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээгээр тогтоож, сар бүр бэлэн бусаар хураана”. гэсэн заалтыг үндэслэн бэлэн бусаар цалин тавьснаас хойш ажлын 5 хоногийн дотор сумын ҮЭ-ийн холбооны дансанд шилжүүлнэ.
- 8.4. Байгууллага дээр гарсан хөдөлмөрийн хамтын маргааныг МУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- 8.5. Үндсэн ажлаасаа чөлөөлөгдөөгүй ҮЭ-ийн сонгуультан болон ҮЭ-ийн гишүүдийг Олон улсын, салбарын, орон нутгийн болон ҮЭ-ийн хурал зөвлөгөөн, сургалт, семинар, дамжаа, туршлага солилцох хурал болон бусад үйл ажиллагаанд оролцох тохиолдолд цалинтай чөлөө олгож оролцуулах арга хэмжээг авна.
- 8.6. Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ болон дотоод журам, ажилтнуудын эрх ашигтай холбогдох асуудлаар аливаа шийдвэр

гаргахдаа ҮЭ-ийн хороо болон салбарын ҮЭ-үүдийн холбоонд ажлын 15 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэж санал авсны үндсэн дээр шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах эрх бүхий хурал, зөвлөгөөнд ҮЭ-ийн төлөөллийг оролцуулна.

9. БУСАД ҮНДЭСЛЭЛ

- 9.1 Эрүүл мэндийн байгууллагын захиргаа, ҮЭ-ийн хорооны 2024-2026 оны энэхүү хамтын гэрээ нь талууд гарын үсэг зурж, сумын ҮЭ-ийн холбооны мөн байгууллагын тамга, тэмдэг дарж, харьяа нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагад бүртгүүлэн, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд дараагийн хамтын гэрээ хүчин төгөлдөр болтол хэвээр мөрдөнө
- 9.2 Хамтын хэлэлцээр хийхтэй холбогдсон зардал болон талууд урьдчилан тохиролцож урьж оролцуулсан мэргэжилтэнд олгох хөлс бусад зардлыг тооцох журмыг талууд хамтран баталж мөрдөнө.
- 9.3 Хамтын гэрээгээр тохиролцсон асуудлыг биелүүлж байгаа нөхцөлд ажил хаялт зохион байгуулахгүй байх асуудлыг ҮЭ-ийн хороо хүлээнэ.

ХАМТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:



ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙГ
ТӨЛӨӨЛЖ
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙГ
ТӨЛӨӨЛЖ ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ДАРГА Б.ДАВАА
НЭМА С.ОДБАЯР
НЯГТЛАН БОДОГЧ Д.ЖАВХЛАН